



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/97/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261628 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит
ХХК, Захирал: Ч.Энхтуяа
Цахим хаяг: enkhtuya@hlab.mn

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОШХ	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ
ДДХ	Дунд даралтын хэсэг
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭХ	Дулааны эрчим хүч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОХУ	Оросын холбооны улс
ӨДХ	Өндөр даралтын хэсэг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ
ЦЭХ	Цахилгааны эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН АГУУР

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

2023.03.15 07/552

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 д заасны дагуу ДЦС-3 ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

ДЦС-3 ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ОХУ-ын Москва хотноо 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан Монгол, Оросын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын ээлжит XXIV хуралдаанаар ДЦС-3 ТӨХК-ийн өргөтгөлийн төслийг хамтран хэрэгжүүлэх хэлэлцээрийг хийсэн байна.

Аудитын гол асуудал

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлыг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган компанийн урсгал зардлаас 749.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Компани нь үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд тусгасан цахилгаан эрчим хүч түгээх зорилтыг 108.2 хувиар, дулааны эрчим хүч түгээх зорилтыг 102.9 хувиар биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,750,076,012.74	3,642,351,256.41
1.1.2	Дансны авлага	14,841,687,708.01	9,584,244,437.73
1.1.3	Татвар НДШ-ийн авлага	1,574,099,298.18	1,618,654,954.48
1.1.4	Бусад авлага	63,973,289.26	33,532,231.53
1.1.6	Бараа материал	10,947,076,483.70	12,016,683,194.19
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	442,014,372.09	1,502,672,360.35
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	333,184,975.60
1.1.8	Эргэлтийн хөрөнгийн дүн	30,618,927,163.98	28,731,323,410.29
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	229,004,522,146.70	220,619,612,021.98
1.2.2	Биет бус хөрөнгө	39,033,550,917.63	39,123,754,352.53
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,765,158.10	-
1.2.4	Дуусаагүй барилга	69,365,352.44	-
1.2.5	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	268,312,203,574.87	259,743,366,374.51
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	298,931,130,738.85	288,474,689,784.80
2	Эргэлтийн бус хөрөнгө		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	8,651,931,665.23	5,416,571,188.48
2.1.1.2	Цалингийн өглөг	2,826,977,622.19	4,042,575,958.73
2.1.1.3	Татварын өр	471,451,618.54	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	848,662,419.30	1,778,140,806.52
2.1.1.6	Хүүний өглөг	146,117,140.93	141,491,696.21
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,670,925.70	98,892,548.32
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	199,133,594.36	112,144,099.73
2.1.1.11	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,151,944,986.25	11,589,816,297.99
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	13,489,006,739.89	11,710,865,933.37
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,396,255,734.58	1,359,339,776.78
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,365,960,064.18	1,989,965,201.34
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	17,251,222,538.65	15,060,170,911.49
2.2	Өр төлбөрийн нийт дүн	30,403,167,524.90	26,649,987,209.48
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч-төрийн	99,362,782,973.56	99,362,782,973.56
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	157,971,926,506.86	157,971,926,506.86
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	38,753,450,000.00	38,922,250,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(27,560,196,266.47)	(34,432,256,905.10)
2.3.5	Эздийн өмчийн дүн	268,527,963,213.95	261,824,702,575.32
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	298,931,130,738.85	288,474,689,784.80

Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	128,421,637,338.54	131,465,185,913.68
2	Борлуулалтын өртөг	118,184,413,802.04	125,961,233,517.27
3	Нийт ашиг (алдагдал)	10,237,223,536.50	5,503,952,396.41
4	Түрээсийн орлого	88,972,426.94	76,583,876.85
5	Хүүний орлого	5,884,435.40	-
6	Бусад орлого	468,273,981.31	645,452,560.31
7	Борлуулалт маркетингийн зардал	197,666,130.67	288,804,752.53
8	Ерөнхий ба удирдлагын зардал	7,683,270,678.56	8,846,025,427.70
9	Санхүүгийн зардал	515,611,935.43	287,049,993.57
10	Бусад зардал	2,379,253,549.33	1,944,965,492.54
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	(1,489.97)	4,906,827.82
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	(1,344,962,301.5)
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	24,550,596.19	(6,480,912,306.45)
14	Орлогын татварын зардал	588,443.53	0.00
15	Татварын дараах ашиг (алдагдал)	23,962,152.66	(6,480,912,306.45)
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	23,962,152.66	(6,480,912,306.45)

Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	99,362,782,973.56	158,066,844,148.39	38,753,450,000.00	(27,696,732,632.66)	268,486,344,489.29
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				112,574,213.53	112,574,213.53
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	158,066,844,148.39	38,753,450,000.00	(27,584,158,419.13)	268,598,918,702.82
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				23,962,152.66	23,962,152.66
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(94,917,641.53)			(94,917,641.53)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,753,450,000.00	(27,560,196,266.47)	268,527,963,213.95
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(379,148,332.18)	(379,148,332.18)
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,753,450,000.00	(27,939,344,598.66)	268,148,814,881.76
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,480,912,306.45)	(6,480,912,306.45)
Өмчид гарсан өөрчлөлт			168,800,000.00		168,800,000.00
Зарласан ногдол ашиг				(12,000,000.00)	(12,000,000.00)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,362,782,973.56	157,971,926,506.86	38,922,250,000.00	(34,432,256,905.11)	261,824,702,575.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	125,404,661,630.65	141,072,578,908.34
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	124,902,279,626.83	140,532,366,457.57
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	304,022,084.70	185,270,102.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	198,359,919.12	354,942,348.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	111,885,707,308.23	127,538,069,758.33
1.2.1	Ажиллагчдад төлсөн	23,611,647,504.22	25,881,239,670.02
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,892,000,000.00	8,453,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	59,690,029,895.43	68,476,752,407.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,611,968,188.60	1,803,259,756.56
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,457,599,056.76	12,694,502,408.21
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	201,049,227.37	55,634,358.30
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,212,859,623.40	7,733,195,931.07
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	51,407,994.00	55,105,890.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,157,145,818.45	2,385,379,336.87
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,518,954,322.42	13,534,509,150.01
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,884,435.40	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	5,884,435.40	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,541,069,861.43	12,416,818,707.01
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,541,069,861.43	12,416,818,707.01
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,535,185,426.03)	(12,416,818,707.01)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,265,760,387.46	225,415,199.33
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	4,265,760,387.46	213,415,199.33
3.2.1	Төлсөн ногдол ашиг	-	12,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,265,760,387.46)	(225,415,199.33)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,718,008,508.93	892,275,243.67
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,032,067,503.81	2,750,076,012.74
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,750,076,012.74	3,642,351,256.41

Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.6 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 он		Зөрүү төлөвлөснөөс	Хувь	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	мян.квтц	1,109,235.6	1,053,616.0	1,085,787.9	32,171.9	3.1	
	ДХЦЭХ	хувь	16.37	17.20	16.88	(0.3)	(1.9)	
		мян.квтц	181,625.8	181,221.0	183,248.2	2,027.2	1.1	
	Эрчим хүчний түгээлт	ЦЭХ	мян.квтц	927,609.9	872,395.0	902,539.8	30,144.8	3.5
		ДЭХ	Гкал	2,466,894.0	2,532,588.0	2,605,683.0	73,095.0	2.9
	Үнийн дүнгээр	ЦЭХ	мян.төг	97,591,175.7	93,226,655.2	96,958,186.9	3,731,531.7	4.0
ДЭХ		мян.төг	30,830,461.6	33,053,585.9	34,506,999.0	1,453,413.1	4.4	
2	Нийт орлого	мян.төг	128,984,772.9	126,844,629.7	132,192,141.5	5,347,511.8	4.2	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	128,421,637.3	126,280,241.2	131,465,185.9	5,184,944.7	4.1	
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	563,135.6	564,388.5	726,955.6	162,567.1	28.8	
3	Нийт зардал	мян.төг	128,960,222.3	138,681,941.7	138,673,053.8	(8,887.9)	(0.0)	
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	342,548.5	252,629.8	241,110.2	(11,519.6)	(4.6)	
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	749,698.8	1,924,773.0	1,873,482.5	(51,290.5)	(2.7)	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал-/	мян.төг	24,550.6	(11,837,312.1)	(6,480,912.3)	5,356,399.8	(45.3)	
5	Цэвэр ашиг /алдагдал-/	мян.төг	23,962.2	(11,837,312.1)	(6,480,912.3)	5,356,399.8	(45.3)	
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.00	1.08	1.04	(0.0)	(3.7)	
7	Нийт авлага	мян.төг	16,479,760.3	9,620,600.0	11,236,431.6	1,615,831.6	16.8	
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	-	-	-	-	-	
8	Нийт өглөг	мян.төг	30,403,167.5	29,192,700.0	26,649,987.2	(2,542,712.8)	(8.7)	
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	13,151,945.0	13,562,600.0	11,589,816.3	(1,972,783.7)	(14.5)	
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	17,251,222.5	15,630,100.0	15,060,170.9	(569,929.1)	(3.6)	
9	Их засвар, ТХБАХ, хөрөнгө оруулалт	мян.төг	14,195,751.4	19,051,228.0	16,655,156.4	(2,396,071.6)	(12.6)	
10	Нийт ажиллагсдын тоо	хүн	989.0	993.0	986.0	(7.0)	(0.7)	
11	Нийт цалингийн сан	мян.төг	27,921,314.9	32,165,859.3	32,135,569.1	(30,290.2)	(0.1)	
12	Нэг ажиллагчийн дундаж цалин	төг	2,352,655.4	2,699,384.0	2,715,079.2	15,695.2	0.6	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ДЦС-3 ТӨХК, түүний үйл ажиллагаа

ДЦС-3 ТӨХК нь “Эх орноо хөгжилд хүргэх эрчим хүчийг бүтээх” эрхэм зорилготой, “Хүний хөгжлийг дээдэлсэн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн эрчим хүчний манлайлагч компани байх” хэтийн зорилготой ажиллаж байна.

ДЦС-3 ТӨХК нь цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Монгол улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 18 хувь, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 40 хувь, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 80 хувийг тус тус ханган ажиллаж байна.

3.2 ДЦС-3 ТӨХК-ийн гадаад, дотоод орчин

ДЦС-3 ТӨХК-ийг Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор 100 хувийн төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан байна. Компанийн удирдлагыг ТУЗ-өөс, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилж байна.

Тайлант хугацаанд Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант хугацаанд ДЦС-3 ТӨХК-ийн дотоод аудитор нь гүйцэтгэх захирлын 2022 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын А, Б тушаалын хэрэгжилт, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл, тээврийн хэрэгсэл, машин механизмуудын ашиглалт, түлш шатахуун зарцуулалт, GPS төхөөрөмжийн ажиллагаанд үнэлэлт өгөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулж буй үйл явц, худалдан авалтын шалгаруулалт, гэрээ байгуулах үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, бараа нийлүүлэлтийн бодит байдалд үнэлэлт өгөх зорилготой дотоод аудитуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Эдгээр аудитаар нийт 26 зөвлөмж өгч ажилласнаас хэрэгжилт хангалттай бөгөөд холбогдох албан хаагчдад хариуцлага тооцуулах санал оруулж шийдвэрлүүлсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ДЦС-3 ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүү бүртгэлийн үйл ажиллагаандаа ДЦС-3 ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны А/384 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тус компани 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,456.4 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,750,076.0	3,642,351.3	892,275.3
Авлага	16,479,760.3	11,236,431.6	(5,243,328.7)
Бараа материал	10,947,076.5	12,016,683.2	1,069,606.7
Урьдчилж гарсан зардал	442,014.4	1,502,672.3	1,060,657.9
Үндсэн хөрөнгө	229,073,887.5	220,619,612.0	(8,384,910.1)
Биет бус хөрөнгө	39,033,550.9	39,123,754.4	90,203.5
Бусад эргэлтийн хөрөнгө	204,765.2	333,184.9	128,419.8
Нийт хөрөнгө	298,931,130.8	288,474,689.8	(10,456,441.0)
Богино хугацаат өр төлбөр	13,151,945.0	11,589,816.3	(1,562,128.7)
Урт хугацаат өр төлбөр	17,251,222.6	15,060,170.9	(2,191,051.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	268,527,963.2	261,824,702.6	(6,703,260.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	298,931,130.8	288,474,689.8	(10,456,441.0)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөр данснуудад материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,642,4 сая төгрөгт хүрч 892.3 сая төгрөгөөр өссөн бөгөөд харилцахын үлдэгдэл 3,630.6 сая төгрөг, үүний 2,000.0 сая төгрөгийг Хаан банканд хадгаламжийн данс нээж, нэг жилийн хугацаатай, 11 хувийн хүүтэй хадгалуулсан;
- Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 5,243.3 сая төгрөгөөр буурсан нь дамжуулах цахилгааны борлуулалтын авлага барагдсан;
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 1,502.7 сая төгрөгт хүрч 1,060.7 сая төгрөгөөр өссөн нь Багануур ХК-д 785.0 сая, Улаанбаатар төмөр зам ХНН-д 428.3 сая, Эрчим тулгуур ХХК-д 105.7 сая төгрөгийн бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж төлсөн нүүрс, тээвэрлэлт, бараа материалын урьдчилгаа тооцоо нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 12,016.7 сая төгрөгт хүрч 1,069.6 сая төгрөгөөр өссөн нь хар төмөр 623.3 сая, засварын сэлбэг 566.1 сая, аваарын нөөцийн үлдэгдэл 359.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 220,619.6 сая төгрөгт хүрч 8,384.9 сая төгрөгөөр буурсан. Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 1,136.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, их засварын зардлын 15,452.7 сая төгрөгийг капиталжуулж, ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрийн дагуу элэгдлээрээ өртөө нөхсөн

3,409.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацаанд 21,565.0 сая төгрөгөөр элэгдэл байгуулсан;

- Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 1,562.1 сая төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх материал болон гэрээт ажлын өр 3,235.4 сая төгрөгөөр буурч урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд ногдох дүнгээр нэмэгдсэн;
- Урт хугацаат өр төлбөр өмнөх оноос 2,191.0 сая төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банк, Нордикийн хөгжлийн сан, эрчим хүчний төслийн дамжуулан зээлийн өрийн тайлант хугацаанд хамаарах дүнг богино хугацаат өр төлбөр дансанд шилжүүлсэн зэргээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу ДЦС-3 ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж батлуулан, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/10 дугаар тушаалаар баталсан ДЦС-3 ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд А/128, А/190 дугаар тушаалуудаар 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Тодотгосон төлөвлөгөөнд нийт орлогыг 126,884.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 138,681.9 сая төгрөгөөр, алдагдлыг 11,837.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтад 19,051.2 сая төгрөгийг баталсан байна.

Тайлант оны гүйцэтгэлээр 132,192.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 138,501.6 сая төгрөгийн зардал гаргаж, 6,309.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь төлөвлөснөөс 5,307.5 сая төгрөгийн орлого илүү төвлөрүүлж, алдагдлыг бууруулж ажилласныг харуулж байна. Орлогын төлөвлөгөөг 104.2 хувиар биелүүлэхэд ЦЭХ, ДЭХ-ний түгээлт нэмэгдсэн, мөн үйл ажиллагааны бус орлого төлөвлөснөөс 162.6 сая төгрөгөөр давсан нь нөлөөлжээ.

Цахилгаан үйлдвэрлэлийн түгээлт нэмэгдсэнээр хувьсах зардал өсөж нийт зардал 138,501.6 сая төгрөг болж тогтмол болон үйл ажиллагааны бус зардал буурсан байна.

Батлагдсан төлөвлөгөөнд ажиллагсадын тоог 993 байхаар баталснаас 7 орон тоо дутуу ажиллаж, 30.3 сая төгрөгийн цалингийн зардлыг хэмнэсэн байна.

Их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу үндсэн тоноглолын 8 их засвар, туслах тоноглолын 126 их засвар, барилгын 7 их засвар, техник зохион байгуулалтын 5 ажил, хөрөнгө оруулалтын 24 ажилд нийт 16,655.2 сая төгрөгийг зарцуулж 87.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДЦС-3 ТӨХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 08 дугаар тогтоолоор өмнөх оны цэвэр ашгийн 50 хувиар бодож 12.0 сая төгрөгийн ногдол ашиг олгохоор баталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу ДЦС-3 ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахаар үндсэн хөрөнгө, худалдан авалттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 11 дүгээр сарын 15-аас 2023 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Гажидмаа, Я.Тэгшбат, аудитор П.Ганчимэг, Ө.Батчимэг, аудиторын туслах А.Отгонсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Билгүүн, захирал Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ДЦС-3 ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/229 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 128,960.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1,289.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны А/85 дугаар тогтоолоор "Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер", "Санхүү эрхэлсэн дэд захирал", "Аж ахуй эрхэлсэн дэд захирал" гэсэн орон тоог тус тус хасаж зардлыг 149.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Энэхүү тогтоолын хүрээнд "Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер"-ийг ерөнхий инженерээр, "Санхүү эрхэлсэн дэд захирал"-ыг төслийн нэгжийн зохицуулагчаар тус тус томилж, цалинг бууруулж хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулсан байна. "Аж ахуй эрхэлсэн дэд захирал" нь хөдөлмөрийн чадвар алдсан нь тогтоогдож, гадаад улсад эмчлүүлэх болсон тул ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн харилцааг цуцалж тэтгэмж олгосон байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дах хэсэгт заасны дагуу сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хэвлэл захиалга зэрэг зардлыг 527.1 сая төгрөгийг хэмнэж, Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд нийт 676.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

ДЦС-3 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал 2022 онд нийт 8.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан боловч Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дүгээр тушаалын хавсралт “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын хүрээнд зохицуулагдсан байна.

Тус станцад бүртгэлтэй автотээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэж заасантай нийцээгүй, холбогдох байгууллагаас нэгдсэн журмаар зохицуулалт хийгдээгүйтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ДЦС-3 ТӨХК нь тайлант онд орлого зарлагын нийт 267,127.9 сая төгрөгийн 2,381 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь ил тод мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийт 55 тендерийн баримт бичгээс нээлттэй тендер шалгаруулалтын 28 тендерийн баримт бичигт тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэх “суурь мэдлэг” олгох сургалтад хамрагдсан гэрчилгээ байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47.6-д “Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

ДЦС-3 ТӨХК-ийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 968.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, залруулаагүй алдаа зөрчилд өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

ДЦС-3 ТӨХК нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн ажлын биелэлтийн тайлбар, нотлох баримтыг 2022 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр ирүүлсэн.

Өмнөх оны аудитаар нийт 254.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 119.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, залруулаагүй алдаа зөрчилд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг дахин хянаж хэрэгжилтийг үнэлэн хүснэгтээр харуулав.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг аудитын явцад дахин хянаж үзээд хэрэгжилтийг 100.0 хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,204.5	1	2,204.5	100.0%
Албан шаардлага	3	143,904.2	3	143,904.2	100.0%
Зөвлөмж	2	5,118.8	2	5,118.8	100.0%
Нийт дүн	6	151,227.5	6	151,227.5	100.0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон анхаарч авч үзэх асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,299.4 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар залруулаагүй нийт 265.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.7 сая төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 25.4 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 238.5 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Үйл ажиллагааны бус зардлын данснаас жилийн засал, автомашины замын торгууль зэрэг үр ашиггүй зардлыг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр ашиггүй зарцуулсан 1.1 сая төгрөгийн зардалд төлбөрийн акт тогтоох.

2. Дотоод болон гадаад томилолтын зардлыг давтан шалгахад томилолтын зардлыг 0.6 сая төгрөгийн зөрүүтэй тооцож олгосон нь Сангийн сайдын 2011 оны 188 дугаар “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай”, Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын зардлын зөрүү 0.6 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Эрчим Хүчний Яамны ТНБД-ын 2022 оны А/125 дугаар тушаалаар ОХУ-руу албан томилолтоор ажилласан ажилтан нь үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлэлгүй 3.5 сая төгрөгийн тээврийн зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

2. Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлээгүйгээс бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнээгүй 3.5 сая төгрөгийн зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

3. Өр төлбөр дансны үлдэгдэлд 4 аж ахуй нэгжийн 8.4 сая, авлага дансны үлдэгдэлд 6 аж ахуй нэгжийн 9.9 сая, нийт 18.3 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг тулган баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

5.3.1 Үндсэн хөрөнгийн бүртгэл

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө дансны 879,739.51 сая төгрөгийн хөрөнгөөс 15,979.44 сая төгрөгийн хөрөнгийг түүвэрт хамруулан шалгахад 238.4 сая төгрөгийн их засварын зардлыг капиталжуулж хөрөнгийн өртгийг нэмэгдүүлсэн боловч ашиглагдах хугацаанд өөрчлөлт ороогүй байгаа нь НБББББ-ийн Үндсэн хөрөнгийн бүртгэл хэсгийн 7 "Ашиглалтын хугацаа"-д "... хөрөнгийн ашиглалтын явцад нэмж гарсан зардал нь капиталчлагдан үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг нэмэгдүүлэх бол ашиглах хугацаанд өөрчлөлт оруулна. ... Энэ тохиолдолд үндсэн хөрөнгийн үлдсэн дүнг шинээр тооцсон ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ ..." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-д зааснаар капиталчлагдсан үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг дахин тооцоолж, элэгдлийн зардлыг уялдуулж зөв бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				/мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Анхан шатны баримтын бүрдлийг шалгах явцад 6 харилцагчийн 20.7 сая төгрөгийн цахим и-баримтыг бүрдүүлээгүй, татварын и-баримт цахим хуудсанд шивүүлээгүй байна.	1	20,703.8	1	20,703.8			1	20,703.8					
Цалингийн хүснэгт болон ХХОАТ тайлангаарх нэр бүхий нэг ажилтны 25.9 сая төгрөгийн орлогыг тайлагнахдаа регистрийн дугаарыг зөрүүтэй тайлагнасан. ХБИ ажилчдын 18.9 сая төгрөгийн орлогыг ХХОАТ-н тайланд тус тус тайлагнаагүй байна.	1	48,440.3			1	48,440.3							
Бусад эргэлтийн бус хөрөнгө дансанд бүртгэлтэй 204.7 сая төгрөг, Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй 128.4 сая төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгээгүй байна	1	333,184.9			1	333,184.9			1	333,184.9			
Өндөр Даралтын Хими Ус Бэлтгэлийн Эсрэг осмосын төхөөрөмж-А секцийн мембран CPA-3 LD8040, Өрлөг дулаалын материал нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний огноо байхгүй. Энэ нь Хууль эрх зүйн талаас гэрээний заалтын гүйцэтгэл болон хэрэгжилтэд хяналт, дүгнэлт хийхэд хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.	1	897,062.6	1	897,062.6			1	897,062.6					
Дүн	4	1,299,391.6	2	917,766.4	2	381,625.2	4	1,299,391.6	4	1,299,391.6			

Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр дансны үлдэгдэлд 4 аж ахуй нэгжийн 8.4 сая, авлага дансны үлдэгдэлд 6 аж ахуй нэгжийн 9.9 сая, нийт 18.3 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг тулган баталгаажуулаагүй Дотоод болон гадаад томилолтын зардлыг давтан шалгахад томилолтын зардлыг 0.6 сая төгрөгийн зөрүүтэй тооцож олгосон	1	18,281.8			1	18,281.8								
Үндсэн хөрөнгө дансны 879,739.51 сая төгрөгийн хөрөнгөөс 15,979.44 сая төгрөгийн хөрөнгийг түүвэрт хамруулан шалгахад 238.4 сая төгрөгийн их засварын зардлыг капиталжуулж хөрөнгийн өртгийг нэмэгдүүлсэн боловч ашиглагдах хугацаанд өөрчлөлт ороогүй	1	238,426.2			1	238,426.2			1	238,426.2				
Эрчим Хүчний Яамны ТНБД-ын 2022 оны А/125 дугаар тушаалаар ОХУ-руу албан томилолтоор ажилласан ажилтан нь үндэсний агаарын тээвэрлэчийг сонгож үйлчлүүлэгүй 3.5 сая төгрөгийн тээврийн зардал гаргасан	1	3,547.9			1	3,547.9								
Бичиг хэрэг, албан хэрэг хөтөллийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлээгүйгээс бичгийн цаас, хувилагч, хэвлэлчдийн хорны зардлыг хэмнээгүй	1	3,561.7			1	3,561.7								
Үйл ажиллагааны бус зардлын данснаас жилийн засал, автомашины замын торгууль зэрэг үр ашиггүй зардлыг зарцуулсан	1	1,149.6			1	1,149.6								
Нийт 55 төндөрийн баримт бичгээс нээлттэй төндөр шалгаруулалтын 28 төндөрийн баримт бичгэнд Төндөрийн үнэлгээний хорооны гишүүдийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх Суурь мэдлэг олгох сургалтанд хамрагдсан гэрчилгээ байхгүй байна.	1	-							1	-				
Дүн	7	265,551.2	2	1,733.6	3	25,391.4	2	238,426.2	2	238,426.2				

СНАГ-2023/97/НА-СТА-ТӨА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023

03

15

396/А0150124

СНАГ-2023/97/НБ-УТБ-ТӨН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

4 аж ахуй нэгжийн 8,392,352.00 /найман сая гурван зуун ерэн хоёр мянга гурван зуун тавин хоёр/ төгрөг, авлагын 6 аж ахуй нэгжийн 9,889,438.41 /есөн сая найман зуун наян есөн мянга дөрвөн зуун гучин найман төгрөг дөчин нэгэн мөнгө / төгрөг нийт 18,281,790.41 /арван найман сая хоёр зуун наян нэгэн мянга долоон зуун ерэн төгрөг дөчин нэгэн мөнгө/төгрөгийн авлага, өр төлбөрийн тулган баталгаажуулалт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага, өр төлбөрийг тулган баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирал /Л.Эрхбаатар/, ерөнхий нягтлан бодогч О.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

Ч.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-й хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2023\03\15 SNAG-13.Docx

0001080873



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТӨХК-ИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

2023 03 15 397/А0150/24
СНАГ-2023/97/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим Хүчний Яамны ТНБД-ын 2022 оны А/125 дугаар тушаалаар ОХУ руу албан томилолтоор ажилласан ажилтан үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлээгүй, 3,547,900.00 /гурван сая таван зуун дөчин долоон мянга есөн зуу/ төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгон үйлчлүүлж байх биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирал /Л.Эрхбаатар/, ерөнхий нягтлан бодогч /О.Энхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД

Ч.ЭНХТУЯА

0001080877



УЛСЫН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн зрхийн хүрээнд хийсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бичиг хэргийн зардлыг өмнөх онтой харьцуулан үзэхэд 3,561,678.45 /гурван сая таван зуун жаран нэг мянга зургаан зуун далан найман төгрөг дөчин таван мөнгө/ төгрөгний зардал илүү гаргасан байна.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, бичиг хэргийн зардлыг хэмнэх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирал /Л.Эрхбаатар/, ерөнхий нягтлан бодогч /О.Энхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ


Ц.НАРАНЧИМЭГ
Ч БОЛД

Ч.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТИ

2023 оны 03 сарын 15 /15/ 14/11/01/01/27
НА С.Доржпүрэгийн НА СГБ ТБА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Дотоод болон гадаад томилолтын зардлыг давтан шалгахад томилолтын зардлыг 584,000 /таван зуун наян дөрвөн мянга/ төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: ... 15.2.3... дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх," гэж, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай", Сангийн сайдын 2018 оны 301 дугаар тушаалаар баталсан "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" журамд тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Томилолтын зардлын зөрүү 584,000 /таван зуун наян дөрвөн мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирал /Л.Эрхбаатар/, ерөнхий нягтлан бодогч /О.Энхбаяр/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		Ч.БОЛД
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ		Ч.ЭНХТУЯА

0001090027



УЛСЫН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 03 15 105/А/0150124

СНАГ-2023/97/НД-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны бус зардлын данснаас жилийн засал, автомашины замын торгууль зэрэгт 1,149,600 /нэг сая нэг зуун дөчин есөн мянга зургаан зуу/ төгрөгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", ...12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад." гэж заасантай нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин үр ашиггүй зарцуулсан 1,149,600 /Нэг сая нэг зуун дөчин есөн мянга зургаан зуу/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захирал /Л.Эрхбаатар/, ерөнхий нягтлан бодогч /О.Энхбаяр/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

Ч.ЭНХТУЯА

0001990025